

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 03 дугаар сарын 17

№ 01

Улаанбаатар хот

*“Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай”*

Компанийн тухай Хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 69.3, 69.6, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын 2.1, 2.3, “Хишиг-Уул” ХК (“Компани” гэх)-ийн дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.32.3-ийг удирдлага болгож, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“ХЭЭХ”)-ыг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Багануур дүүрэг, Нацагдоржийн гудамж хаягт байрлах Компанийн байранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсүгэй. Үүнд:
 - Нэг.** Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - Хоёр.** Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - Гурав.** Компанийн 2023 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
 - Дөрөв.** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
 - Тав.** “Хэрлэн” худалдааны төвийн дээврийн капитал их засварын ажлыг хийх зээлийн асуудлыг шийдвэрлэх.
3. ХЭЭХ-г хуралдуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор зохих баримт бичгийн хамт хүргүүлсүгэй.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр байхаар тогтоосугай.
5. Хурал зохион байгуулах комисст дараах нэр бүхий хүмүүсийг томилсугай:
 - i. Гүйцэтгэх захирал Я.Нэргүй
 - ii. Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН-н ахлах хуульч С.Батчимэг

- iii. Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН-н хуульч А.Солонго
 - iv. Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН-н хуульч Ш.Цэрэндолгор
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2022 оны 04 дүгээр сарын 3-ны өдрийн дотор өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, бүртгэл, хаяг нь тодорхой хувьцаа эзэмшигч нарт бичгээр мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Я.Нэргүй, тооллогын комиссын даргаар Нийслэлийн өмчийн газрын томилогдсон төлөөлөгч, гишүүнээр Ш.Цэрэндолгорыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



Д. ГОНГОР

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 03 дугаар сарын 17

№ 02

Улаанбаатар хот

*“Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн
талаарх дүгнэлтийг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн
хуралд танилцуулж, батлуулах тухай”*

Компанийн тухай Хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”, “Хишиг-Уул” ХК (“Компани” гэх)-ийн дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.32.3-ийг удирдлага болгож, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хуралдаж ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж, гаргасан дүгнэлтийг Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, батлуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

